

ӨВӨЛ АЙСУЙ, АЛИМ, ЖИМСНИЙ МОДОО ӨВӨЛД БЭЛДЭЭРЭЙ!



Бид өвлийг угтан дулаан хувцасаа бэлддэг шиг тарьсан алим, чавга, жимс, жимсгэний мод бутгаа ч бэлддэг. Алим, чавга, лийр, интоор гэх мэт ,, харь гаригийн,, мэт жимсийг хашаандаа тарьсаар бас ч үгүй хэдэн өвлийг үдчихлээ. Анх тарьж байсан хоббитнууд маань өвөлд бэлдээд сурчихсан. Харин шинээр таригчиддаа зориулан мэдээлэл оруулж байна.

1. Модны тогооны эргэн тойрны хөрсийг (одоогоор газар таг хөлдөөгүй байгаа үед) хүрзээр сийрүүлж өгнө. Унасан хуучин навчийг авч шатаана.

2. Хэдэн жилийн өмнө тарьсан мод, буттай бол залуужуулах тайралт хийнэ. Та модоо сайтар ажиглаарай. Эхний ээлжинд хугарсан үхэжсэн, өвчилсөн мөчирийг тайрна. Мөн нарны тусгалыг хаасан мөчрүүдийг тайрч , цөөлж болно. Гэхдээ модны таналт тайралт нь нарийн, тодорхой хэмжээний мэдлэг шаардсан ажил тул томорсон алим, чавга, интоорын мод бутны тайралтын талаар өвөл сургалт хийхээр төлөвлөж байгаа болно

3. Хэрэв Танд хорхой шавьжны эсрэг бодис (искра, децис, каратэ гэх мэт маш олон бодис гадуур байдаг) байгаа бол хүрзээр эргүүлсэн хөрс рүү, мөн модны иш, орой руу сайтар шүршиж цацсанаар хорхой шавьжийг устгах боломжтой. Одоо амжаагүй бол хавар 4 сард заавал цацаарай.

4. Тарьснаас хойш 3 жил болсон модны ишийг зориулалтын шохойгоор будаж өгвөл хаврын (2 сар гарангуут нарны хурц туяанд иш нь түлэгдэж эхэлдэг) нарны туяаны түлэгдэлтээс хамгаалж чадна.

5. Тогоо буюу үндэс хэсгийг үртэс, бууц, эдгээр нь олдохгүй тохиолдолд шороогоор хучна. Хучихдаа доор нь хуучин даавуун эдлэл, шуудай зэргийг дэвсээд дээр нь үртэс, бууцаа 10-15 см орчим зузаантай асгаж өгөөрэй. Цас оронгуут дахин цасаар дээш нь овойлгон хучих нь зүйтэй.

Яагаад заавал хучих гэж? Манайд тариалж буй сортын модны үндэсүүд –(15-16) хэмийг давах чадвартай байдаг. Цас ороогүй өвөл бол огт хучлагагүй модны үндэс шууд хөлдөх аюултай. 2017, 2018 онд шинээр тарьсан ялангуяа чавга, интоорын мод, буттай бол зориулалтын цагаан (спандбонд мэтийн)материалаар модоо ороогоорой. Нялх, нарийн мөчрүүд хүйтэнд хөлддөг. Ажигласнаар чавга, интоор, зарим сортын улаан үхрийн нүд зэрэг нь эхний жилд мөчир нь дээрээсээ хөлдөх нь бий. Үүнд санаа зоволтгүй хавар хөлдөж хатсан хэсгийг тайрахад зундаа саглайж ургасаар 3 дахь зунаас иш бүдүүрэн цаашид дажгүй ургаж байгаа.

6. Хэрвээ? Таны талбайд хулгана оготоно, туулай зэрэг мэрэгчид байгаа бол модны ишийг хуучин нейлон терко, хар цаас, картон гэх мэт гарын доорх зүйлсээр ороох хэрэгтэй болно. Эсвэл кареолин, мазь вишневский гэх мэт хурц үнэртэй бодисыг даавуунд шингээн модныхоо ишний ойр байрлуулна. Ингэснээр үргээх боломжтой болдог. Мөн барилгын сантехникийн дулаалгын материалыг зүсч углаж ч болно. Сүүлийн үед манайхан ундааны хуванцар савыг зүсч ишний хэсэгт углан завсараар нь үртэс, өвс зэргээр чигжиж байгаа нь зөв шийдэл мэт.

7. Модны дээд хэсгийг бордоская смесь, медный купорос буюу зэсийн байвантай бодисуудаар шүршиж өгснөөр элдэв өвчнөөс сэргийлж чаддаг.

8. Өдийд , мөн үүнээс арай хүйтрэх тэр мөчид цэнэг усалгааг сайн хийж өгөөрэй. Үндэс хэсэг 20-30 см гүнд чийг авсан байх ёстой. Цэнэг усалгаа хийнгүүт тун удахгүй хөрс

хөлддөг. Ингэж хөлдсөн чийг нь хавар газар гэсч эхлэхэд таны модыг чийгтэй байлгаж өгдөгөөрөө нэн тустай юм.

9. Дараа жилээс 8 сарын дундуураас эхлэн фосфор, калийн бордоогоор бордсоноор мод нь дархлаажиж өвлийг өнөтэй давахад бэлтгэгддэг сайн талтай. Эдгээр бордоог ашиглаагүй бол модны болон аргалын үнс модны тогоо руу хийж байхад дээрх бордооны тодорхой хувийг орлодог сайн талтай.

Ингээд л та модоо өвөлдөө бэлдчихлээ.Танд амжилт хүсье.

